



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН  
2025 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**



## АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	3
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	4
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	5
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	6
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	8
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	8
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	10
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...11	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	12
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	13
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	13
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	14
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	14
3.4 Зээлийн чанарын талаар.....	15
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	18
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	18
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	19
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	19
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	20
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	20
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	21
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	22
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	22
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	22
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	23
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	24
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	24

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025.11.14


Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2025 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 176 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 ХЗХ буюу 3.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт ХЗХ-дын 52.8 хувь буюу 93 ХЗХ орон нутагт, 47.2 хувь буюу 83 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 23 ХЗХ-ны 86 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 8 ХЗХ-ны гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2021	2022	2023	2024	2025. III
ХЗХ-ны тоо	209	196	191	178	176
Шинээр олгосон	-	7	3	4	5
Хүчингүй болгосон	40	20	8	17	7
Түдгэлзүүлсэн	12	4	10	4	5
Сэргээсэн	1	3	1	2	1
ТЗ-ийн хугацаа сунгасан	85	62	-*	-*	-*

\*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 6.6 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол гишүүдийн тоо дунджаар 1.4 хувиар, тэр дундаа орон нутгийн гишүүдийн тоо 5.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо, гишүүдийн мэдээлэл (хот, орон нутаг)

	2021. III	2022. III	2023. III	2024. III	2025. III	Дүрсгэл
Нийт ХЗХ-дын тоо	225	202	192	183	176	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	127	110	101	92	83	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	98	92	91	91	93	■ ■ ■ ■ ■
Нийт гишүүдийн тоо	75,771	72,770	71,649	74,847	78,172	■ ■ ■ ■ ■
Улаанбаатар	44,842	40,739	38,887	40,442	41,557	■ ■ ■ ■ ■
Орон нутаг	30,929	32,031	32,762	34,405	36,615	■ ■ ■ ■ ■


## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2025 оны 3 дугаар улирлын байдлаар 176 ХЗХ 69 салбар, 590 ажилтан, 78,172 гишүүн (77,817 иргэн, 355 хуулийн этгээд)-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод Багахангай дүүргээс бусад дүүрэгт 83 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Монгол Улсын 21 аймагт 93 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 ХЗХ буюу 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



### 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2025 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,325 буюу 4.4 хувиар өсөж 78,172-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 51.3 хувь буюу 40,125 нь эмэгтэй, 0.5 хувь буюу 355 нь хуулийн этгээд, үүний 32.4 хувь буюу 115 нь эмэгтэй удирдлагатай байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 53.2 хувь буюу 41,557 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 46.8 хувь буюу 36,615 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)




Нийт 176 ХЗХ-ны 27.8 хувь буюу 49 ХЗХ 20-100 гишүүнтэй, 53.4 хувь буюу 94 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.8 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 8.0 хувь буюу 14 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 50.0 хувь буюу 7 ХЗХ Улаанбаатар хотод, 50.0 хувь буюу 7 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд (интервалаар)	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	49	2,614	3.3%
101-500 гишүүнтэй	94	21,894	28.0%
501-1,000 гишүүнтэй	19	13,571	17.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	14	40,093	51.3%
<b>Нийт</b>	<b>176</b>	<b>78,172</b>	<b>100.0%</b>

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 14 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 51.3 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



## 1.4 Бодлого, зохицуулалтын орчин

### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

#### Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн

##### 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 2024 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 169 ХЗХ-оос тайланг улирлын байдлаар 92.3 хувь буюу 156 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

#### Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- ХЗХ-д Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-ны 61.9 хувь буюу 109 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 51.4 хувь буюу 56 ХЗХ нийслэлд, 48.6 хувь буюу 53 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

#### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2025 оны 3 дугаар улирлын байдлаар зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 95 ХЗХ-оос 75 ХЗХ 45,554.90 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

#### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 15 ХЗХ Монголбанкны СМА-д 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 9,071,006.97 мянган төгрөгийн 180 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-тэй хамтран Хүртээмжтэй ногоон санхүүжилтийг хадгаламж зээлийн хоршоодоор нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаж байна. Төслөөр БЖДҮ эрхлэгчдэд тохирсон ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хадгаламж, зээлийн хоршоодод бий болгож, хөгжүүлснээр орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/76 дугаар тушаалаар байгуулсан “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж, тайлагнах” үүрэг бүхий ажлын хэсгийн “Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлын эрсдэлийн үнэлгээ хийх” дэд ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/171 дугаар тушаалаар байгуулагдаж, хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлыг үнэлж, ажлын хэсгийн эхний хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-оос 2025 оны 3 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд 9 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан болно.

### 2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд


Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>83</b>	<b>47.2%</b>	<b>93</b>	<b>52.8%</b>
<b>Нийт гишүүдийн тоо</b>	<b>78,172</b>	<b>100.0%</b>	<b>41,557</b>	<b>53.2%</b>	<b>36,615</b>	<b>46.8%</b>
Эрэгтэй	37,692	48.2%	18,313	48.6%	19,379	51.4%
Эмэгтэй	40,125	51.3%	22,973	57.3%	17,152	42.7%
Гишүүн хуулийн этгээд	355	0.5%	271	76.3%	84	23.7%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	115	32.4%	75	65.2%	40	34.8%
<b>Гишүүдийн насжилт</b>	<b>77,817</b>	<b>100.0%</b>	<b>41,286</b>	<b>53.1%</b>	<b>36,531</b>	<b>46.9%</b>
18-35 насны	18,427	23.7%	9,706	52.7%	8,721	47.3%
36-45 насны	23,954	30.8%	13,419	56.0%	10,535	44.0%
46-55 насны	18,353	23.6%	9,519	51.9%	8,834	48.1%
56-аас дээш	17,083	21.9%	8,642	50.6%	8,441	49.4%
<b>Гишүүдийн боловсрол</b>	<b>77,817</b>	<b>100.0%</b>	<b>41,286</b>	<b>53.1%</b>	<b>36,531</b>	<b>46.9%</b>
Дээд	34,660	44.5%	22,959	66.2%	11,701	33.8%
Тусгай дунд	13,442	17.3%	8,185	60.9%	5,257	39.1%
Бүрэн дунд	17,111	22.0%	7,656	44.7%	9,455	55.3%
Дунд	9,322	12.0%	2,128	22.8%	7,194	77.2%
Бага	3,282	4.2%	358	10.9%	2,924	89.1%
<b>Нийт ажилтнуудын тоо</b>	<b>590</b>	<b>100.0%</b>	<b>324</b>	<b>54.9%</b>	<b>266</b>	<b>45.1%</b>
<i>Үүнээс: Эмэгтэй</i>	432	73.2%	234	54.2%	198	45.8%
<b>Санхүүгийн програмтай</b>	<b>95</b>	<b>54.0%</b>	<b>35</b>	<b>36.8%</b>	<b>60</b>	<b>63.2%</b>
<b>Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо</b>	<b>15</b>	<b>100.0%</b>	<b>11</b>	<b>73.3%</b>	<b>4</b>	<b>26.7%</b>
Гүйлгээний тоо	180	100.0%	164	91.1%	16	8.9%
Гүйлгээний дүн (мян.төг)	9,071,006.97	100.0%	8,559,880.97	94.4%	511,126.00	5.6%
<b>Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>
Сэжигтэй гүйлгээний тоо	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Сэжигтэй гүйлгээний дүн (мян.төг)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%

2025 оны 3 дугаар улиралд нийт ХЗХ-дын 8.5 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 9,071,006.97 мянган төгрөгийн 180 гүйлгээг мэдээлсэн байна. Үүний 94.4 хувь буюу 8,559,880.97 мянган төгрөгийн 164 гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 5.6 хувь буюу 511,126.00 мянган төгрөг бүхий 16 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн ба сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Нийт ХЗХ-дын 54.0 хувь буюу 95 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Нийт 590 ажилтны 54.9 хувь буюу 324 нь

Улаанбаатар хотын ХЗХ-нд, 45.1 хувь буюу 266 нь орон нутгийн ХЗХ-нд ажиллаж байна.


График 4: ХЗХ-ны гишүүдийн насжилт (хот, орон нутгаар)



Нийт гишүүдийн 44.5 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 66.2 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 54.4 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин (хот, орон нутгаар)



Хүснэгт 5: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>83</b>	<b>47.2%</b>	<b>93</b>	<b>52.8%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>294,774,448.85</b>	<b>100.0%</b>	<b>217,584,320.28</b>	<b>73.8%</b>	<b>77,190,128.57</b>	<b>26.2%</b>
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>28,616</b>	<b>100.0%</b>	<b>11,853</b>	<b>41.4%</b>	<b>16,763</b>	<b>58.6%</b>
Иргэн	28,500	99.6%	11,751	99.1%	16,749	99.9%
Эмэгтэй	16,664	58.5%	6,820	58.0%	9,844	58.8%
Хуулийн этгээд	116	0.4%	102	0.9%	14	0.1%
Эмэгтэй удирдлагатай	44	37.9%	37	36.3%	7	50.0%
<b>Зээлдэгчдийн насжилт</b>	<b>28,500</b>	<b>100.0%</b>	<b>11,751</b>	<b>41.2%</b>	<b>16,749</b>	<b>58.8%</b>
18-35 насны	6,928	24.3%	3,204	27.3%	3,724	22.2%
36-45 насны	8,720	30.6%	3,843	32.7%	4,877	29.1%
46-55 насны	7,109	24.9%	2,614	22.2%	4,495	26.9%
55-аас дээш	5,743	20.2%	2,090	17.8%	3,653	21.8%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>28,500</b>	<b>100.0%</b>	<b>11,751</b>	<b>41.2%</b>	<b>16,749</b>	<b>58.8%</b>
Дээд	10,997	38.6%	6,060	51.6%	4,937	29.5%
Тусгай дунд	4,352	15.3%	1,945	16.5%	2,407	14.4%
Бүрэн дунд	7,097	24.9%	2,415	20.6%	4,682	27.9%
Дунд	4,688	16.4%	1,213	10.3%	3,475	20.7%
Бага	1,366	4.8%	118	1.0%	1,248	7.5%

Тайлант улиралд ХЗХ-д 28,616 зээлдэгчийн 294,774,448.85 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 41.4 хувь буюу 11,853 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 73.8 хувь буюу 217,584,320.28 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 58.6 хувь буюу 16,763 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 26.2 хувь буюу 77,190,128.57 мянган төгрөгийг бүрдүүлж

байна. Нийт зээлдэгчийн 99.6 хувь буюу 28,500 нь хувь хүн (58.5 хувь буюу 16,664 эмэгтэй), 0.4 хувь буюу 116 нь хуулийн этгээд байна. Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 10,301.04 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 18,356.90 мянган төгрөг, орон нутагт 4,604.79 мянган төгрөг байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс: Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>176</b>	<b>100.0%</b>	<b>83</b>	<b>47.2%</b>	<b>93</b>	<b>52.8%</b>
<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>260,155,845.06</b>	<b>100.0%</b>	<b>197,743,336.20</b>	<b>76.0%</b>	<b>62,412,508.86</b>	<b>24.0%</b>
<b>Нийт хадгаламж эзэмшигчийн тоо</b>	<b>46,185</b>	<b>100.0%</b>	<b>23,546</b>	<b>51.0%</b>	<b>22,639</b>	<b>49.0%</b>
Иргэн	46,088	99.8%	23,492	99.8%	22,596	99.8%
<i>Эмэгтэй</i>	25,748	55.9%	12,385	52.7%	13,363	59.1%
Хуулийн этгээд	97	0.2%	54	0.2%	43	0.2%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	45	46.4%	15	27.8%	30	69.8%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>8,613,587.78</b>	<b>3.3%</b>	<b>6,739,499.86</b>	<b>3.4%</b>	<b>1,874,087.92</b>	<b>3.0%</b>
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	6,622	14.3%	5,278	22.4%	1,344	5.9%
Иргэн	6,575	14.2%	5,237	22.2%	1,338	5.9%
Хуулийн этгээд	47	0.1%	41	0.2%	6	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>251,542,257.28</b>	<b>96.7%</b>	<b>191,003,836.34</b>	<b>96.6%</b>	<b>60,538,420.94</b>	<b>97.0%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	39,563	85.7%	18,268	77.6%	21,295	94.1%
Иргэн	39,513	85.6%	18,255	77.5%	21,258	93.9%
Хуулийн этгээд	50	0.1%	13	0.1%	37	0.2%
<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	<b>46,088</b>	<b>100.0%</b>	<b>23,492</b>	<b>100.0%</b>	<b>22,596</b>	<b>100.0%</b>
18-35 насны	16,069	34.9%	10,847	46.2%	5,222	23.1%
36-45 насны	11,303	24.5%	4,882	20.8%	6,421	28.4%
46-55 насны	9,447	20.5%	3,717	15.8%	5,730	25.4%
56-аас дээш	9,269	20.1%	4,046	17.2%	5,223	23.1%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>46,088</b>	<b>100.0%</b>	<b>23,492</b>	<b>100.0%</b>	<b>22,596</b>	<b>100.0%</b>
Дээд	19,511	42.4%	12,446	53.0%	7,065	31.3%
Тусгай дунд	5,821	12.6%	2,347	10.0%	3,474	15.4%
Бүрэн дунд	10,043	21.8%	4,137	17.6%	5,906	26.1%
Дунд	6,374	13.8%	1,549	6.6%	4,825	21.3%
Бага	4,339	9.4%	3,013	12.8%	1,326	5.9%

2025 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 46,185 хадгаламж эзэмшигчийн 260,155,845.06 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 51.0 хувь буюу 23,546 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 76.0 хувь буюу 197,743,336.20 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 49.0 хувь буюу 22,639 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 24.0 хувь буюу 62,412,508.86 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2025 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 380,004,744.52 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.2 хувь буюу 25,429,140.19 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 14.3 хувийг хугацаагүй, 85.7 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 46,088 нь хувь хүн (55.9 хувь буюу 25,748 эмэгтэй), 0.2 хувь буюу 97 нь хуулийн этгээд (46.4 хувь буюу 45 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,632.91 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 8,398.17 мянган төгрөг, орон нутагт 2,756.86 мянган төгрөг байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 9.8 хувь буюу 26,373,672.99 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 8.6 хувь буюу 20,494,505.70 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 18.2 хувь буюу 10,353,841.90 мянган төгрөгөөр, нийт зарлага 20.0 хувь буюу 9,113,570.69 мянган

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 12,769,122.00 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ

үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 61.9 хувь буюу 109 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны III улирал	2025 оны III улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>354,575,604.33</b>	<b>380,004,744.52</b>	<b>25,429,140.19</b>	<b>7.2%</b>
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.5%		
<b>Нийт зээл</b>	<b>268,400,775.86</b>	<b>294,774,448.85</b>	<b>26,373,672.99</b>	<b>9.8%</b>
Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.7%		
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>6,715,500.41</b>	<b>8,738,990.27</b>	<b>2,023,489.86</b>	<b>30.1%</b>
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.5%	3.0%	0.5%	18.6%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.4%	0.1%	32.0%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>239,661,339.36</b>	<b>260,155,845.06</b>	<b>20,494,505.70</b>	<b>8.6%</b>
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%		
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>28,643,912.57</b>	<b>29,972,207.92</b>	<b>1,328,295.35</b>	<b>4.6%</b>
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>49,856,382.77</b>	<b>56,342,160.20</b>	<b>6,485,777.43</b>	<b>13.0%</b>
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>15,494,555.43</b>	<b>2,000,988.66</b>	<b>-13,493,566.77</b>	<b>-87.1%</b>
Нийт орлого	56,984,496.20	67,338,338.10	10,353,841.90	18.2%
Нийт зарлага	45,455,645.41	54,569,216.10	9,113,570.69	20.0%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>11,528,850.79</b>	<b>12,769,122.00</b>	<b>1,240,271.21</b>	<b>10.8%</b>

## 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 83 ХЗХ-ны нийт хөрөнгө 288,237,108.26 мянган төгрөг нь зах зээлийн 75.9 хувь, нийт зээл 217,584,320.28 мянган төгрөг нь зах зээлийн 73.8 хувь, нийт хадгаламж 197,743,336.20 мянган төгрөг нь зах зээлийн 76.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8 хувь буюу 840,807.33 мянган төгрөгөөр өсч 6,510,955.39 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.0 хувийг эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 16.4 хувь буюу

6,980,191.81 мянган төгрөгөөр, нийт зарлага 17.1 хувь буюу 5,805,150.30 мянган төгрөгөөр, цэвэр орлого 1,175,041.52 мянган төгрөгөөр өсөж 9,944,526.93 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 67.5 хувь буюу 56 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны III улирал	2025 оны III улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>277,408,050.30</b>	<b>288,237,108.26</b>	<b>10,829,057.96</b>	<b>3.9%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	78.2%	75.9%	-2.3%	-3.0%
<b>Нийт зээл</b>	<b>204,797,519.71</b>	<b>217,584,320.28</b>	<b>12,786,800.57</b>	<b>6.2%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	76.3%	73.8%	-2.5%	-3.3%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>5,670,148.06</b>	<b>6,510,955.39</b>	<b>840,807.33</b>	<b>14.8%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	84.4%	74.5%	-9.9%	-11.7%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.8%	3.0%	0.2%	6.9%

<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>188,132,942.73</b>	<b>197,743,336.20</b>	<b>9,610,393.47</b>	<b>5.1%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	78.5%	76.0%	-2.5%	-3.2%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>20,584,973.24</b>	<b>21,306,088.82</b>	<b>721,115.58</b>	<b>3.5%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	71.9%	71.1%	-0.8%	-1.1%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>37,610,567.66</b>	<b>42,055,209.89</b>	<b>4,444,642.23</b>	<b>11.8%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	75.4%	74.6%	-0.8%	-1.0%
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>15,370,825.36</b>	<b>1,828,695.13</b>	<b>-13,542,130.23</b>	<b>-88.1%</b>
Нийт орлого	42,619,103.08	49,599,294.89	6,980,191.81	16.4%
Нийт зарлага	33,849,617.66	39,654,767.96	5,805,150.30	17.1%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>8,769,485.41</b>	<b>9,944,526.93</b>	<b>1,175,041.52</b>	<b>13.4%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 93 ХЗХ-ны нийт хөрөнгө 91,767,636.26 мянган төгрөг нь зах зээлийн 24.1 хувь, нийт зээлийн үлдэгдэл 77,190,128.57 мянган төгрөг нь зах зээлийн 26.2 хувь, нийт хадгаламж 62,412,508.86 мянган төгрөг нь зах зээлийн 24.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.5 хувь буюу 3,373,650.09 мянган төгрөгөөр, нийт зарлага 28.5 хувь буюу 3,308,420.39 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

2,824,595.07 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 57.0 хувь буюу 53 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны III	2025 оны III	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>77,167,554.03</b>	<b>91,767,636.26</b>	<b>14,600,082.23</b>	<b>18.9%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	21.8%	24.1%	2.3%	10.8%
<b>Нийт зээл</b>	<b>63,603,256.15</b>	<b>77,190,128.57</b>	<b>13,586,872.42</b>	<b>21.4%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	23.7%	26.2%	2.5%	10.5%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>1,045,352.35</b>	<b>2,228,034.89</b>	<b>1,182,682.54</b>	<b>113.1%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	15.6%	25.5%	9.9%	63.4%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.5%	1.0%	0.5%	104.8%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>51,528,396.63</b>	<b>62,412,508.86</b>	<b>10,884,112.23</b>	<b>21.1%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	21.5%	24.0%	2.5%	11.6%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>8,058,939.34</b>	<b>8,666,119.10</b>	<b>607,179.76</b>	<b>7.5%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	28.1%	28.9%	0.8%	2.9%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>12,245,815.11</b>	<b>14,286,950.31</b>	<b>2,041,135.20</b>	<b>16.7%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	24.6%	25.4%	0.8%	3.1%
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>123,730.06</b>	<b>172,293.53</b>	<b>48,563.47</b>	<b>39.2%</b>
Нийт орлого	14,365,393.12	17,739,043.21	3,373,650.09	23.5%
Нийт зарлага	11,606,027.75	14,914,448.14	3,308,420.39	28.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>2,759,365.37</b>	<b>2,824,595.07</b>	<b>65,229.70</b>	<b>2.4%</b>

## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2024 оны III улирал		2025 оны III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>345,324,059.66</b>	<b>97.4%</b>	<b>366,007,158.05</b>	<b>96.3%</b>	<b>20,683,098.39</b>	<b>6.0%</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>64,890,839.58</b>	<b>18.3%</b>	<b>54,648,041.97</b>	<b>14.4%</b>	<b>-10,242,797.61</b>	<b>-15.8%</b>
Бэлэн мөнгө	3,440,040.36	1.0%	3,266,288.56	0.9%	-173,751.80	-5.1%
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	14,864,435.80	4.2%	16,064,241.01	4.2%	1,199,805.21	8.1%
Банканд байршуулсан хадгаламж	42,784,447.75	13.1%	31,409,733.21	8.3%	-11,374,714.54	-26.6%
Замд яваа мөнгө	9,168.47	0.0%	500,000.00	0.1%	490,831.53	5,353.5%
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	-	0.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,792,747.21	1.1%	3,407,779.19	0.9%	-384,968.02	-10.2%
<b>Зээл (цэвэр)</b>	<b>273,988,458.99</b>	<b>77.3%</b>	<b>301,121,240.73</b>	<b>79.2%</b>	<b>27,132,781.74</b>	<b>9.9%</b>
Нийт зээл	268,400,775.86	75.7%	294,774,448.85	77.6%	26,373,672.99	9.8%
Хэвийн зээл	253,367,381.74	71.5%	273,622,380.41	72.0%	20,254,998.67	8.0%
Хугацаа хэтэрсэн зээл	8,317,893.71	2.3%	12,413,078.16	3.3%	4,095,184.45	49.2%
Чанаргүй зээл	6,715,500.41	1.9%	8,738,990.28	2.3%	2,023,489.87	30.1%
Зээлийн хойшлогдсон орлого	550.00	0.0%	-	-	-550.00	0.0%
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	10,403,111.91	2.9%	12,435,430.67	3.2%	2,032,318.76	19.5%
(Зээлийн эрсдэлийн сан )	4,835,759.28	1.4%	6,088,638.80	1.6%	1,252,879.52	25.9%
Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	20,880.49	0.0%	-	0.0%	-20,880.49	0.0%
<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>6,444,761.09</b>	<b>1.8%</b>	<b>10,237,875.35</b>	<b>2.7%</b>	<b>3,793,114.26</b>	<b>58.9%</b>
Дансны авлага (цэвэр)	1,844,752.57	0.5%	377,924.80	0.1%	-1,466,827.77	-79.5%
Дансны авлага	1,844,752.57	0.5%	377,924.80	0.1%	-1,466,827.77	-79.5%
Хувь хүнээс авах авлага	516,229.15	0.1%	297,808.21	0.1%	-218,420.94	-42.3%
Хуулийн этгээдээс авах авлага	1,328,523.42	0.4%	80,116.59	0.0%	-1,248,406.83	-94.0%
(Авлагын эрсдэлийн сан)	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Холбоотой талаас авах авлага	3,797,892.43	1.1%	9,197,622.73	2.4%	5,399,730.30	142.2%
Ажиллагчдаас авах авлага	29,082.11	0.0%	17,776.75	0.0%	-11,305.36	-38.9%
Салбар хоорондын тооцоо	5,984.03	0.0%	-	0.0%	-5,984.03	0.0%
Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	212,473.63	0.1%	630,561.48	0.2%	418,087.85	196.8%
Бусад	554,576.32	0.2%	13,989.60	0.0%	-540,586.72	-97.5%
<b>САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>9,251,544.67</b>	<b>2.6%</b>	<b>13,997,586.47</b>	<b>3.7%</b>	<b>4,746,041.80</b>	<b>51.3%</b>
<b>Татварын авлага</b>	<b>432,818.21</b>	<b>0.1%</b>	<b>236,992.71</b>	<b>0.1%</b>	<b>-195,825.50</b>	<b>-45.2%</b>
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	144.99	0.0%	9,030.13	0.0%	8,885.14	6,128.0%
Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,248,688.89	0.9%	3,517,283.08	0.9%	268,594.19	8.3%
Бараа материал	220,482.54	0.1%	292,141.03	0.1%	71,658.49	32.5%
Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	634,006.79	0.2%	1,047,133.04	0.3%	413,126.25	65.2%
Бусад санхүүгийн бус хөрөнгө	159,767.88	0.0%	2,268,927.72	0.6%	2,109,159.84	1,320.1%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	4,386,776.41	1.2%	4,500,512.93	1.2%	113,736.52	2.6%
Биет бус хөрөнгө (цэврээр)	168,858.96	0.0%	2,125,565.83	0.5%	1,956,706.87	1,158.8%
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>354,575,604.33</b>	<b>100.0%</b>	<b>380,004,744.52</b>	<b>100.0%</b>	<b>25,429,140.19</b>	<b>7.2%</b>

2025 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 380,004,744.52 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.2 хувь буюу 25,429,140.19 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.3 хувийг

санхүүгийн хөрөнгө, 3.7 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 14.4 хувийг, цэвэр зээл 79.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.8 хувь буюу 26,373,672.99 мянган төгрөгөөр өсөж 294,774,448.85 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 6,088,638.80 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин чанаргүй зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.1 хувь буюу 2,023,489.86 мянган төгрөгөөр өсөж 8,738,990.27 мянган төгрөг, хугацаа

хэтэрсэн зээл 49.2 хувь буюу 4,095,184.45 мянган төгрөгөөр өсөж 12,413,078.16 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад дунджаар 10.7 хувиар өссөн. Нийт зээлийн хэмжээ дунджаар 12.7 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 5.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгө, зээлийн багцын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)

	2021.Ш	2022.Ш	2023.Ш	2024.Ш	2025.Ш	Дүрслэл
ХЗХ-ны тоо	225	202	192	183	176	■ ■ ■ ■ ■
Нийт хөрөнгө	289.4	266.7	302.7	354.6	380.0	■ ■ ■ ■ ■
Нийт зээл	208.1	216.1	222.0	268.4	294.8	■ ■ ■ ■ ■
Чанаргүй зээл	8.0	7.8	6.9	6.7	8.7	■ ■ ■ ■ ■

### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 5 ХЗХ-ны нийт хөрөнгө 219,973,421.97 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 57.9 хувийг, гишүүдийн тоо 20,819 байгаа нь нийт гишүүдийн 26.6 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	5	219,973,421.97	57.9%	20,819	26.6%
2	1,000,000.0 -10,000,000.0	38	124,566,944.34	32.8%	33,486	42.8%
3	500,000.0-1,000,000.0	24	16,389,422.46	4.3%	8,949	11.4%
4	100,000.0-500,000.0	66	16,501,638.87	4.3%	11,872	15.2%
5	50,000.0-100,000.0	28	2,191,375.71	0.6%	2,321	3.0%
6	10,000.0-50,000.0	13	377,852.27	0.1%	665	0.9%
7	10,000.0 хүртэл	2	4,088.90	0.0%	60	0.1%
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>380,004,744.52</b>	<b>100.0%</b>	<b>78,172</b>	<b>100.0%</b>



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 294,774,448.85 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 77.6 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 301,121,240.73 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 79.2 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.43 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.15 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.34 хувь, орон нутгийн ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.70 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 38 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 89.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	38	262,637,673.73	89.1%
2	500,000.0-1,000,000.0	19	13,049,657.41	4.4%
3	100,000.0-500,000.0	67	16,522,061.43	5.6%
4	50,000.0-100,000.0	27	1,968,210.12	0.7%
5	10,000.0-50,000.0	19	591,774.85	0.2%
6	10,000.0 хүртэл	3	5,071.31	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	3	-	-
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>294,774,448.85</b>	<b>100%</b>

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
